

# МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

## ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№19/496

ШУС, НУС

2018

### ХЯТАДЫН БАРЛАХ ХЭВЛЭЛИЙН ТҮҮХ

Ван Ан Лун\*

\*БНХАУ-ын Бээжингийн Багшийн Их Сургуулийн Сэтгүүл зүй олон нийтийн харилцааны сургуулийн профессор

**Түлхүүр үг:** хэвлэлийн дурсгал, хэвлэх технологи, түүний ангилал, барлах хэвлэл, хэвлэлийн түүх.

**М**онгол дахь үйсэн дээрх сурвалж бичиг. Монгол Улсад, түүнчлэн Ази, Европын зарим газруудад хусны холтсон бичгийн төрөл дурсгал бий. Хусны холтос ер бусын хатуу бөгөөд бичих материалын төрөл зүйлд хамруулж болно. 1990-ээд онд Монголын уран зохиол, түүний төрлийн судалгааны ажлын эхний нээсэн олдворт хусны холтос буюу үйсэн дээрх олон тооны бичиг олдсон байдаг. Уран зохиолын түүхэн сурвалж материалд энэ нь 1960 онд хуучнаар ЗХУ-ын нутгаас олдсон эртний булшинд хадгалагдаж байсан гэдэг. Алтан Ордын улс буюу улаан Урус хаантай холбогдох цаг хугацаанд бичигдсэн дурсгал болов уу гэсэн судлаачдын дэвшүүлсэн таамаг бий. Алтан ордын улс нь (*ойролцоогоор 1243-1502 он*) Дундад зууны үед Волга мөрний эрэгт оршиж байсан гэж түүхэнд тэмдэглэгдсэн байдаг. Үйсэн дээрх бичиг дүрс бүхий дурсгал нийт 25 хуудас байсан гэдэг. 13-р зууны үеийн уран зохиолын судалгаагаар уг бичигт сөрөг агуулгатай үг 7 байсан гэж үзжээ. Хуудас 13-т “Хүүгийнхээ тухай

бас улс түмний айдастай хэсэг мөн, бусдын айдас нь хүүхэд шиг миний хүүд иржээ” зэрэг агуулга бүхий утга зохиолын төрөлд багтах дурсгалд тооцогддог. Харин 1951 онд, Ново Грийнобл бүс нутгаас ухаж гаргасан олдворт үйсэн дээрх бичгийн дурсгал харьцангуй их хэмжээтэйгээр олдсон гэдэг. Түүнчлэн 1970 онд Н.Пурселл, Е.Ша Фу Ку Ноуфу тэргүүтэй судлаачдаар удирдуулсан судалгааны баг мөн эртний хотын шинэ Чилин Су модны байршлаас гадна Монголын хуурай өмнөд хэсгийн 12 км газраас мөн ийм төрлийн олдвор олсон байгаа юм. Зөвлөлтийн судалгааны багийнхнаар ахлуулсан судлаачид Монголын түүх, уран зохиолтой холбогдох олон дурсгалыг нээж илрүүлсэн байдаг. Дээрх судар бичгийг газрын гүнд 8-9 метр ухаж байж нээж илрүүлсэн бөгөөд хагас нурсан суурьтай байсан тухай тэмдэглэжээ. Хус холтос буюу үйсэн дээрх бичиг нийтдээ 1400-аас дээш ширхэг олдож эрдэмтэн, уран зохиолын судалгааны ажилд хувь нэмрээ оруулсан байдаг. Хусны холтсон бичгийн зарим дурсгал 17-р зууны эхний хагаст багтах цаг үетэй холбогдох тохиолдол ч мөн бий гэнэ. Ийм төрлийн олдворууд Монгол, Төвд зэрэг улсад бүртгэгдсэн байдаг.

2000 онд Германы Төв Азийн Институтын доктор Элизабет Човын судалгааны үр дүнг Хетимур Баргарсон дахь Шинжлэх ухааны академи хусны холтос гэж тогтоосон байна. Үйсэн дээр бичигдсэн 42 төрлийн 240 ширхэг уран зохиолын бүтээлүүд бүртгэгдсэн гэдэг тоо бий. Эдгээрийн дотор Бурханы шашинтай холбоотой судар бичгүүд ч үйсэн дээр бичигдсэн байдлаар олддог юм. Зарим судлаачдын зүгээс Монголд хус холтосын уран зохиолын судалгааг өргөн хүрээнд өргөжүүлэх зорилгоор угсаатны зан заншил, түүх соёл, ёслол, тахилга зэрэг баялаг агуулгатай болгож судлагаа эхэлсэн тохиолдол байдаг. Хус холтосын уран зохиол дахь олдворууд нь үйсэн дээрх уран зохиолыг дагнан судалдаг судлаачдын хувьд чухал ач холбогдолтой дурсгал юм. Тухайлбал, Монгол Улсын Харамбан хотод олдсон гар бичмэлүүд жишээ нь жижиг хус холтосны үзэсгэлэнгийн гарын авлага дээр бичсэн богино өгүүлүүд байдаг бөгөөд эдгээр нь зөөврийн гэж тооцогддог.

Монгол хус холтосын уран зохиол Хятадын Хэйбэй мужид хус холтос хэвлэгддэг нь гайхалтай зүйл юм. Хусан холтосын соёл нь үндэсний уламжлалт соёл юм. Хусан холтосны бүтээгдэхүүн нь хэлбэр дүрслэхэд хялбар, хөнгөн, ус үл нэвтрэх, гэмтээх, бусад шинж чанар, ялангуяа байнгын нүүдэллэхэд хялбар байдаг. Дэлхийд Манж Чин гүрний эзэн Канси хааны үед ном уншихдаа: “Хус, титэм, гутал, чингэлгийн завь дансны завь бүгд хус арьс юм” гэж хүртэл дурдсан байдаг нь үйс нь маш бат бөх шинж чанартайг илтгэнэ.

Жил бүр билгийн тоололын 5, 6-р саруудад хусны холтос нь янз бүрийн төрлөөр хэвлэлийн хэрэглэгдэхүүн

болж иржээ. Хуурай холтсоор хучигдсан царцдасыг хавтгайруулан, давтаж, эсвэл галаар ээсэн хус холтос илүү уян хатан болж, хүссэн хэлбэрт оруулах боломж ч байдаг.

Үүний зэрэгцээ “Орочен” хүмүүс хус модыг ашиглан бүх төрлийн сав, аяга, хайрцаг, бусад сав суулгыг хийдэг. Ороченийн амьдрал, үйлдвэрлэлд хус модны холтос өргөн тархсанаас үүдэн “хус ой”, “таван овгийн уул” зэрэг олон төрлийн домог, ардын дуу гарч ирсэн байдаг юм.

**Х**ятадын барлах хэвлэлийн түүх. Хэвлэлийн түүх бол хүн төрөлхтний соёл иргэншлийн түүх юм. “Хэвлэн нийтлэх” гэдэг нь хүн төрөлхтний соёл иргэншил, түүнээ уламжлан дамжуулах, түгээх зам, хэрэгсэл юм. “Хэвлэл” гэж нэрлэгдэх бүтээл нь олон нийтийн үйл ажиллагааны гэрч гэж хэлж болно. Энэ нь тодорхой нэг агуулгыг олон тоонд хуулбарлаж түүнийгээ мэдээллийн хэрэгслээр түгээхэд чиглэсэн нийгмийн үйл ажиллагаа юм. Хэвлэн нийтлэх үндсэн үүрэг бол чухамдаа хүн төрөлхтний мэдлэг, мэдээллийг цуглуулж, нээн илрүүлж, шалгах, түгээх, өвлүүлэх үйл явц билээ.

Хэвлэлийн судалгаа голчлон дараах дөрвөн үе шаттай явагддаг. Нэгдүгээрт хэвлэл мэдээллийн түгээгч, хоёрт хэвлэн нийтлэх бэлгэдэл, гуравт хэвлэлийн технологи, дөрөвт нийтлэх үйл ажиллагаа болоод бүтээл (*хэвлэл, хэвлэн нийтлэгч, хэвлэн нийтлэх систем, нийтлэл төлөвлөлт, нийтлэл засварлах болон түүнийгээ нийтлэх, бүтээгдэхүүнээ түгээх, худалдаалах бизнес...* гэх мэт).

Нэгдүгээрт, хэвлэл мэдээллийн түгээгч буюу дамжуулагчийн үүднээс авч үзье. Хүмүүн төрөлхтний хэвлэл

мэдээллийн түүх, түүнийг түгээх үйл явц маш онцгой шинж чанар, үе шатыг туулсаар өнөөг хүрсэн. Тэр дундаас хамгийн томоохонд тооцогдох нэгэн онцлог бол хатуугаас зөөлөн, томоос жижиг, бичил хэсгээс макро, хамгийн бага хэмжээтэй мэдээллээс хамгийн том далайцтай мэдээлэл болон хувирах хүртэлх хөгжлийн маш олон үе шатыг туулан энэ эрин зуунд иржээ.

**Х**өгжлийн эхэн үедээ ваар, шавар шахмал, мал, амьтны яс, яст мэлхийн хуяг, чулуугаар хийсэн хөшөө, хулсан модон шахмал, дал модны навч, хусны холтос болон бусад хатуулаг эд зүйлсийг ашиглаж байсан бөгөөд аажмаар боловсронгуй болон хөгжсөөр торго даавуу, ангийн шир, цаас, шилэн ургамал судалж түүн дээрээ хэвлэн нийтлэж эхэлсэн түүхтэй. Түүнчлэн цаашлаад зөөлөн хуванцар дээр нийтлэх болж, дараа нь дуу, гэрэл, цахилгаан, соронзон чанар, мөн виртуал хагас чип зөөгчийг ашиглан виртуал хэвлэл мэдээллийн нийтлэл, улмаар цахилгаан соронзон дуу, гэрлэн нийтлэл, компьютерийн нийтлэл, дижитал нийтлэл, бусад виртуал нийтлэлийн хэлбэрийг нээн судалж түүнийгээ хөгжүүлсээр иржээ. Ирээдүйд ч мөн ялгаагүй робот хэвлэгч болон тархины ойлголт нь илүү бодитой ухаалаг шинэ хэлбэрийн хэвлэн нийтлэлийн шинэ арга технологиуд төрөх болно. Энэ ч үүднээс хүн төрөлхтний хэвлэлийн түүхийг үндсэн гурван шатанд хуваан авч үзлээ:

(А) *"Шинэ соёл иргэншил"* -ийн үе буюу хатуу биет хэвлэлийн эрин. Хатуу биет дээрх хэвлэл нь соёл иргэншлийг нээх чухал хэрэгсэл болж чадсан гэж үздэг. Хүн төрөлхтний хамгийн анхны хэвлэн нийтлэх үйл явц болон хэвлэл түгээх асуудал нь хатуу

биет дээрх хэвлэлээс улбаатай. Хамгийн энгийнээр бодоход эхний алхам бол хамгийн анхан шатны хэвлэлийг бий болгох юм. Тиймээс хатуу биет хэвлэл нь хэвлэн нийтлэх онолын үндэс суурийг тавьсан. Хүн төрөлхтний соёл иргэншлийн бичгийн дурсгалын дунд анхны хэлбэр болох шавар шахмал эм, чулуу, хад, керамик байгууламж, хаш ширхэг болон бусад хатуу биет дээр хэвлэн нийтлэх эхлэл тавигдаж, энэ нь улмаар хүний соёл иргэншлийн анхны шавыг тавихад чухал үүрэг гүйцэтгэжээ.

(В) *"Зөөлөн"* буюу зөөлөн чанарын хэвлэл. Хэдийгээр хатуу хэвлэлийн эрин хэвлэн нийтлэх түүхэн дэх чухал үйл явц хэдий ч удаан хугацаанд хадгалж үлдэх төдийлөн боломжгүй байлаа. Учир нь хатуу эд материал дээр бичих нь төдийлөн амар байгаагүй бөгөөд, түүнийгээ түгээх, олон тоогоор хэвлэхэд хүнд гээд гэх мэт олон асуудалтай тулгарч байсан юм. Тиймээс хямд, уян хатан, эвхэгддэг, зөөлөн, түүнчлэн илүү их мэдээллийг багтаах боломжтой зөөлөн хэвлэлийн эрин үе өмнөх үеэсээ илүү давамгайл байр суурийг эзэлж эхэллээ. Хятад улс анх торго даавууг хэвлэн нийтлэлд ашиглаж эхэлснээр зөөлөн хэвлэлийн эрин маш далайцтайгаар хүчээ авч эхлэв. Гэвч үнийн хувьд төдийлөн тохиромжтой биш байсан учраас үйсэн хэвлэл илүү их байр суурийг эзлэх болсон юм. Баруун зүгт папирусыг олборлож эхэлсэн нь хатуу хэвлэлийн байр суурийг орлож эхэлсэн. МЭӨ хоёрдугаар зуунаас Цай Лүний үе хүртэл Хятад улс хатуу эдийг орлуулсан олдоц ихтэй, хямд, зөөлөн, өнгийн цаасан дээр хийгдсэн түүхий эдийг хэвлэн нийтлэлд зориулан үйлдвэрлэж эхлэв. Хэвлэн нийтлэх түүхийн эхэн үе болох хатуу материал

дээрх хэвлэлээс зөөлөн хэвлэлийн хөгжлийн явцыг тавдугаар зууны эхэн хүртэл хамарсан байдаг. Барууны орнуудад зөөлөн хонины арьсан цаас нь олон наст ургамлаас гаргасан цаасыг орлож, хатуу хэвлэлийн байр суурийг эзлэв.....МЭӨ тавдугаар зууны эхэн үед, зүүн Жин гүрний Хуан сшүэний зарлигаар болох "Жэйн нэрийн баримт бичиг"-ийн нөлөөгөөр зөөлөн хэвлэлийн эрин үе түүний хөгжил хорьдугаар зууныг хүртэл 1600 жилийн туршид хүн төрөлхтний соёлын хамгийн гол хөдөлгөгч хүчин байсаар ирсэн билээ. Хэвлэн нийтлэх салбарт ургамлын шилэн цаасыг өргөнөөр тарааж, дэлхий нийтэд түгээн дэлгэрүүлсэн нь хүний хэвлэн нийтлэлийн векторын "Зөөлөн хэвлэл" үйл явцыг төгс төгсгөл болгосон. Гэхдээ хайгуулын ажил дуусаагүй гэдгийг дурдах хэрэгтэй.

(С) *"Хязгаар үгүй хийх виртуал хэвлэлийн эрин.* Хэвлэлийн дамжуулагчийн хөгжил бүхэлдээ өөрчлөгдөж, хамгийн зөөлөн, хөнгөн нимгэн тэр чигтээ виртуал болон хувирч, хамгийн жижиг хэмжээтэй мэдээллээс хамгийн өргөн цар хүрээг хамарсан, эсвэл, хязгааргүй өргөн цар хүрээтэй, хэмжигдэхүйц дамжуулалт, хүлээн авалт илүү хялбар, хурдан болж шинэчлэгдэж эхлэв. 18-р зууны эхэн үеэс хүн төрөлхтөн шинэ дуу, гэрэл, цахилгаан эрчим хүч, соронзон гэх зэрэг шинэ нээлтийг судалж, аажмаар үүнийг хэвлэн нийтлэх үйл явцдаа ашиглаж эхэлсэн бөгөөд энэ нь хэвлэлийн орчинд аажмаар боловсорч эхэлсэн. Хүмүүс эдгээр шинэ дамжуулагч, шинэ хэвлэл мэдээллийн хэрэгслийг дуу, дүрс, хөдөлгөөнт зураг, бусад зүйлсийг тэмдэглэх, түүнийгээ дамжуулах, зөөвөрлөхөд ашиглаж эхэлсэн бөгөөд энэ нь хүн төрөлхтний хэвлэн нийтлэх виртуал хэвлэлийн шинэ эрин үеийг

нээсэн юм. Дуу болон гэрлийн цахилгаан соронзон виртуал хэвлэлийн эхэн үеийн үр хөврөлийн үе шат нь компьютерийн хувьсгалыг виртуал хэвлэн нийтлэх хэвлэлийн өнөөгийн төлөв байдалд шилжүүлэхэд чиглэсэн. Өнөө үед дижитал хэвлэлийн практик хурдацтай явагдаж, байнгын шинэчлэл хөгжлийн байдалд оржээ. Дижитал хэвлэлийн онолын дүгнэлт болон, эрдэм шинжилгээний судалгаа нь хайгуулын ажлын өөрчлөлт, сэтгэлгээг хөгжүүлэхэд оршино.

**В**иртуал хэвлэлийн ирээдүй нь аажмаар хүн төрөлхтөний оюунлаг хөгжил дэвшилтийг бий болгодог бөгөөд робот хэвлэл болон ухаалаг хэвлэл нь ирээдүйн хэвлэлийн урьдчилсан хэлбэр юм. Юуг анхаарах ёстой вэ гэвэл, нээлттэй соёл иргэншлийн үеийн хатуу хэвлэлээс зөөлөн хэвлэлийн эринлүү, зөөлөн хэвлэлийн үеэс агуулгын виртуал хэвлэн нийтлэлийн эрин үед шилжин ирж байна. Эдгээр гурван үе шатууд, түүнчлэн шат бүрт хэд хэдэн дотоод үйл явцууд нь бүрэн шилжилтийн, бүрэн солигддоггүй бөгөөд шилжилт, хөндлөн огтлолцол, эсвэл зэрэгцээ хөгжүүлэлтийн үед ихэвчлэн тохиолддог. Жишээ нь, одоог хүртэл хэрэглэгдсээр байгаа яс, хулс зэрэг нь соёлын болон бүтээлч бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлдэг хэвлэлийн хэрэглэгдэхүүн байсаар байна. Гэсэн хэдий ч шат бүрийн гол шинж чанар нь маш тодорхой хэвээр байна.

Хоёрдугаарт, хэвлэн нийтлэлийн технологийн тухайд авч үзэхэд хатуу хэвлэлийн эхэн үед, яс, чулуу, хулс, хуулга, улалж, навч болон хясаа зэрэг нь ихэвчлэн, сийлбэр, уран зураг хийхэд ашиглагддаг хийц, хэвлэлийн технологийн арга хэрэгсэл байсан. Ялангуяа засварлах болон бичих нь

хатуу хэвлэлийн үеийн хамгийн чухал хоёр хуулбарлах хэрэгсэл байсан. Тиймээс, бичиг зохиолын ажил мэргэжил эрхэлдэг хүмүүсийг “Үзэг хэрэглэгч” гэж нэршиж заншсан байв. “Хэвлэн нийтлэх” эсвэл “Хувилан хэвлэх” зэрэг эдгээр нэршил нь үнэндээ МЭӨ долдугаар зууны тэртээх Тан гүрний үеэс улбаатай. Арван нэгдүгээр зууны үеийн Хятадын Сүн гүрний үед шавраар шинэ төрлийн хөдөлдөг хэвлэлийн шинэ бүтээлийг зохион бүтээжээ. 15-р зууны дунд үед, Германы Гутенбергийн шинэ бүтээл болох төмөр хөдлөгч хэвлэн нийтлэх бүтээл бол орчин үеийн хэвлэлийн салбарын эх суурийг тависан бүтээл болж чадсан юм. Орчин үед хүн төрөлхтөн цоо шинэ бүтээлүүд болох “цахилгаан, дууны болон гэрлийн” шинэ аудио-видео нийтлэх технологи, дуун компьютер болон хоёртын дижитал хэвлэлийн технологи, виртуал хэвлэлийн технологи зэрэг бүтээлүүдийг нээн илрүүлээд хоёр зуугаад жилийг ардаа үджээ.

**Д**ижитал хэвлэлийн технологийн шинэчлэл ирээдүйд зогсолтгүй урагшлахын сацуу, илүү тодорхой болж ихээхэн ахиц дэвшлийг үзүүлэх болно. VR, AR, хүн-компьютерийн харилцаа нь шинээр гарч ирж цоо шинэ чиг хандлагыг бий болгож байна.

Гуравдугаарт, хэвлэн нийтлэх тэмдэгтийн үүднээс харахад хэвлэн нийтлэх гэдэг нь хэвлэлийн технологийг хэвлэн нийтлэх бэлгэдэл болон түүнийгээ түгээх үйл явцыг хэлнэ. Хэвлэн нийтлэх тэмдгийн гурван үндсэн элементүүд болох хэвлэлийн тэмдэг, вектор хэвлэн нийтлэх, хэвлэлийн технологийн хоорондын харилцан үйлдэл нь хүний хэвлэн нийтлэлийн практикийг хөгжүүлэх, өөрчлөх инновацийг бий болгодог. Хэв-

лэн нийтлэх гурван үндсэн элементийн дотроос соёлын хамгийн гайхалтай өв болоод хүмүүний соёл иргэншлийн нэг чухал явдал бол үсгийн тэмдэглэгээг нийтэлсэн систем юм. Хүний соёл иргэншлийн ололт амжилт бүр өөр өөр шинэ тэмдгийг бий болгодог. Хэвлэлийн судалгааны үүднээс харвал, тэмдэг бичих нь хүний соёл иргэншлийг бүртгэх, хадгалж, дамжуулах чухал үндэслэл болоод чухал нөхцөлүүдийн нэг юм. Хятадын ханз үсгэн тэмдэгтүүд, талбайн тэмдэгтүүд нь эртний хэвлэлийн технологийн хөгжлийн процесс дэх хэвлэн нийтлэх чухал технологи. Цагаан толгой үсгийн тэмдэгтүүд бол бичгийн хэв шинжийн онцлогтой нийцэж байгаа юм. Месопотами Күнэйформ (*мөн "хадаасны тав дээрх" гэж нэрлэдэг*) нь шавар банзан хавтанг сийлбэрлэсэн буюу товойлгон жижиг модон саваа, зэгс мод хэрэглэж сийлж үлдээсэн бичвэрүүд юм. Эртний Египетийн глафсууд нь папирус цаас бөгөөд тус цаасан дээр үзгээр бичихэд тохиромжтой байв. Харин эртний Энэтхэгийн хувьд, навчин дээр бичдэг байсны сацуу, зүү ашиглан бичихэд зориулагдсан байв. Текст тэмдэглэгээний шинж чанарууд нь нийтлэх технологи болон хэвлэлийн машинуудын онцлогтой маш их хамааралтай байдаг.

Дөрөвдүгээрт, хэвлэн нийтлэх үйл ажиллагаа болоод ололт амжилт. Хэвлэлийн технологийг хэвлэн нийтлэгчтэй нийлүүлэхийн тулд технологийг ашиглах энэ үйл явц нь өөрөө нийтлэх үйл ажиллагаа бөгөөд хэвлэлийн үйл ажиллагааны шууд үр дүн юм. Энэ нь нийтлэгч, хэвлэн нийтлэгч, хэвлэлийн байгууллага хоёулаа, хэвлэн нийтлэхэд таатай хэвлэлийн систем буюу дараах үйл явцыг агуулдаг, үүнд хэвлэн нийтлэх, хэвлэн нийтлэх



төлөвлөлт, нийтлэл засварлах болон хэвлэлийн үйлдвэрлэл, хэвлэлийн инновацийн төгсгөлгүй үйл ажиллагаа түүнийгээ дэлгэрүүлэх хөгжүүлэх зэрэг багтана.

Дээрх дөрвөн асуудал бол бидний судалгаа шинжилгээний ажлын гол судлагдахуун бөгөөд түүнчлэн тус ном болох "Хятад, гадаадын нийтлэлийн түүх"-ийн логик үндэслэл юм. Хүний соёл иргэншлийг нээх үйл явц, хэвлэн нийтлэх статус, инноваци, ололт амжилтуудын үндсэн нөхцөл байдлын талаархи "Иргэний соёл иргэншлийг хэвлүүлэх нь" номонд онцгойлон тодорхойлсон.

Үнэн хэрэгтээ хүн төрөлхтний түүхийн туршид үлдээсэн дурсгалуудаас судлах шинэчлэл хийх шаардлагатай түүх, соёлын хуримтлалууд одоо ч хэвээр байна. Судалгааны өнцгөөс харвал хэвлэлийн түүх, хүн төрөлхтний соёл иргэншлийн үүсэл, хөгжил, хувьсал зэрэг салбар асар өргөн хүрээтэй. Түүхийн явцад бий болсон бичиглэл, тэмдэг, тэдгээрийн шинэчлэл, сайжруулсан хэвлэлийн технологитой хэвлэх газрууд гэх мэт төмрийн хүдэр хайлуулж эхэлсэн бичгийн бүтээлээр уран зохиол төдийгүй бүртгэл хүртэл эхэлсэн гэж үздэг юм. Соёл иргэншлийн шилжилтийн нэг үед хамаардаг 1958 онд АНУ-ын Дорно дахины судлалын хүрээлэнгийн Чикагогийн их сургуульд эрдэм шинжилгээний хурал болсон байдаг. Энэ хурал дээр Америкийн Антропологич Клюкхохн Энгельсийн "Гэр бүл, хувийн өмчөөс гаралтай улс орон" гэдгийг архелогийн олдворуудын гарал үүсэл баталдаг гэж цохон тэмдэглэсэн байдаг. Түүнчлэн "Ойрх дорнодоос гаралтай соёл иргэншил" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд Их Британийн археологич

Даниел соёл иргэншлийн гурван шалгуурын нэг нь бичиг тэмдэглэгээ юм гэж баталсан нь бий. Соёлын системийн гол цөм нь бичгийн соёл. Гэвч бичиг үсэггүй соёл иргэншлийг байж боломгүй гэдэг цонхоор харж болохгүй. Ямарч соёл иргэншилд тодорхой агуулга бүхий тэмдэг тэмдэглэгээ байдаг учраас хүмүүст үлдсэн соёлын хуримтлал системтэйгээр хадгалагдаж ирэх бололцоо байгаагүй гэж тодорхойлсон юм.

**А**фрик тивд хүн төрөлхтөний соёл иргэншлийн эртний дурсгалууд цөөнгүй бий. Тэр дундаа бичгийн соёлын түүхийн хэсэг ч багтдаг. Африкаас гаралтай хатуу биет дээрх хэвлэмэл дурсгалыг гурван хэсэгт хувааж үзэж болно. Нэгдүгээрт, балар эртний хадны сүг зураг хэлбэртэй бичгийн дурсгал. Хоёрт, эвлэмэл бүтээгдэхүүний дурсгал юм. Энэ нь зөөвөрлөж авч явдаг чулуу, мод, металл болон эртний Египет хэвлэмэл дурсгалуудыг багтаадаг. Гуравдугаарт, Ша Өвсний цаасан дээр бичмэл хэлбэрээр нийтэлсэн дурсгалуудыг нэрлэдэг. Дээрх бичгийн соёлын дурсгалууд өөр өөр хэлбэр хийцтэй ч бие биедээ ямар нэгэн байдлаар уусан эгдэж хөгжиж ирсэн чиг хандлагатай. Хойд Африкийн хувьд Танзанийн бунхан дахь хадны сүг зураг тив дэлхий даяар алдартай. Өвөрмөц сийлбэр бичлэг, сургаалийн агуулга бүхий маш баялаг дүрс бичгийн дурсгалууд удаа дараа олдсон жишээ бий. Гэхдээ тивийн хувьд бүс нутгийн хөгжлийн тэнцвэргүй байдалтай холбоотойгоор бичгийн дурсгалын олдоц харилцан адилгүй байдаг. Эдгээр дурсгалуудад уран зохиолын асар арвин сан хөмрөг багтдаг. Нэн тэргүүнд Хойд Африк болон Зүүн Африкийн уран зохиолын дээжийг нэрлэж болно. Үүний дараагаар Өмнөд Африк, Төв

Африкийн дурсгалууд жагсана. Эртний Африкийн дурсгалуудын дээжид эртний Египетийн дурсгалуудыг оруулдаг. Үүнд асар олон тооны мөн олон төрлийн бичгийн соёлын хэвлэмэл дурсгалууд багтдаг. Эртний Африкийн бичгийн соёлын билгэдлийн хэлбэр нь гол төлөв дүрс бичиг хэлбэртэй, хүн төрөлхтөний түүхэн дэх хамгийн эртний бичгийн соёлын нэг юм. Түүхийн явцад дээрх бичгийн бүтэц, хэлбэр гээд өөрчлөлт явагдсаар аажмаар биет хэлбэрийн бичиг, биеийн дохионы хэл болоод Коптик бичгийн соёл хүртлээ хөгжсөөр ирсэн байдаг. Бичиг соёлын дурсгалуудаас (*Мин булш, сүм Мин, бичээс болон ил бичээс*), барлах арга, хэвлэлийн бичмэл ашиглаж байсан гэж тодорхойлогдсон байдаг. Хатуу бичмэл дурсгалын хувьд бага зэрэг зөөлөн өвөрмөц шинж чанар ажиглагдаж эхэлсэн бөгөөд үүнээс улбаатайгаар хатуу хэлбэртэй байсан хэвлэлийн шинж чанар зөөлөн хэлбэрт шилжих эхлэл тавигдсан гэж үздэг.

**Э**ртний Месопотами соёл иргэншил нь дэлхийн хамгийн эртний бичгийн иргэншлийн нэг бөгөөд ийм төрлийн номын шавар хувилбар нь дэлхийн хамгийн эртний хатуу хэлбэртэй мэргэн ухаан, оюун санаа нь дэлхий дээр хамгийн эрт соёл урлаг, шинжлэх ухаан технологийг бүтээсэнд зүй ёсоор тооцогддог юм. Эртний соёл урлаг, шинжлэх ухаан зэргийг тэмдэглэж авч үлдээнэ гэдэг бол хүн төрөлхтөний түүхэнд үлдсэн гялалзсан сувд гэсэн үг. Месопотами, Баруун Плайнс буюу тал нутагт хамаарах хөрсний түүхий эдийг олж илрүүлэх нь харьцангуй хялбарт тооцогддог. Тухайлбал Месопотамийн Шумерийн соёл иргэншил тал нутгийн хөрснөөс түгээмэл олдсон байдаг. Олдворуудын бүртгэлээс шавар шахмал бичгийн

дурсгал түгээмэл олддог бөгөөд энэ дурсгалуудад дэлхий ертөнцийн тухай мэдээлэл бас хадгалагдаж үлдсэн байдаг нь сонирхолтой.

Шумерын эзэнт гүрний Месопотами инноваци хувьслын замаар бичгийн соёлоо хөгжүүлж иржээ гэж харж болохоор. Түүнчлэн Ассирийн Эзэнт гүрэн Бавилоны эзэнт гүрний бичгийн дурсгал нь бодитой шинэчлэл явагдсан илүү боловсронгуй тэмдэгт ашигласан байдаг. Мөн эртний Египетийн хэлхээс, Хятад гаралтай тэмдэгттэй төсөө бүхий дүрс ашиглаж бичгийн соёлын бүрэн системийг бий болгосон байдал ажиглагддаг юм. Орчин үеийн судлаачдын археологийн малтлагын үр дүнд олдсон шавар дурсгалуудад аман баатарлаг туульсын болоод сонгодог гэж нэрлэж болохуйц цуглуулга хүртэл олдсон байдаг юм. Энэ бүгдийг Месопотами судлагааны ажилд болоод хатуу биетийн хэвлэмэл бүтээлийн судалгааны ажилд чухал үүрэг гүйцэтгэх чухал материал гэж дүгнэдэг юм.

Хятадад бүртгэгдсэн эртний хэвлэмэл судар бичгийг олдворууд зөөвөрлөх үүрэгтэй, мөн барласан тэмдэглэгээтэй, хатуу хэвлэмэл зэрэг үндсэн онцлог шинж чанартай байна. Зөөврийн хэлбэртэй олдворуудад олс, ваар, чулуу, хаш, яс, хүрэл, хулсан хуулга буюу үйс зэргийг дурдаж болно. Яс, хүрэл зэрэг хатуу биет дээр хэвлэж ирсэн судар бичгийн соёлд хулсны хуулга буюу үйс онцгой үүрэг гүйцэтгэж, олон хувиар хэвлэн түгээх боломжийг харьцангуй нэмсэн байдаг. Эртний бичгийн соёлын тэмдэг, болон барлан нийтлэх арга барилын хөгжил хоорондоо харилцан уялдаатай. Химийн бодис хэрэглэн бичгийн дурсгалыг хадгалж үлдээнэ гэдэг нарийн төвөгтэй байсан нь ойлгомжтой.

Чухамдаа энэ арга барилаар л соёл иргэншлийн билэг тэмдэг болсон судар бичиг өнөө үетэй золгосон. Энэ л билэг тэмдгийн тусламжтайгаар дүрс зураг бичиг болтлоо хөгжиж эцэстээ эссэ эмхтгэл ном болон тархах үндэс суурь тавигдсан юм.

Түүнчлэн эртнээс өдгөө бидэнд өвлөгдсөн судар бичгийн тусламжтайгаар л эртний хүмүүсийн түүхийн хөгжил, мөн ямар хууль дүрмээр амьдарч ирсэнийг таамаглах бололцоо бүрдэж байна. Бичгийн дурсгалын тусламжтайгаар бид хүн төрөлхтөний түүхэн дэх соёл иргэншил, үзэл суртал, соёлын хувьсгал гээд хөгжлийн бүх үе шатанд өмнөх бичгийн соёлын нөлөө хатуу биет дээр хэвлэгдэн ирсэн бичгийн дурсгалаар дамжин мэргэн ухаан нь нь өвлөгджээ гэж хэлж болно. Судар бичиг дэх бичгийн соёлын дурсгал билэгдлийн мөн практик хандлагатайгаар өнөөгийн бидэнд дамжиж ирж байна. Энэ бүхний тусламжтайгаар соёл дэвшил, технологийн хөгжил бидэнд хэвлэмэл бүтээлийн дурсгалаар дамжин ирж байгаа нь эртний Хятадын бүх зүйл харилцан уялдаатай явагддаг зарчмыг та бидэнд өвлүүлсээр байгаа юм.

Өмнөд Ази нь мөн л төрөлхтний эртний соёл иргэншлийн өлгий нутаг юм. Эртний Энэтхэгээс гаралтай соёл ингэншлийн баялаг өв соёл цөөнгүй бий. Хатуу биет хэвлэмэл соёл иргэншлийн дурсгал үүнд багтдаг юм. Тухайлбал эртний нууц тамга бүхий бичээс, Ашока бичээс, санскритаас эхлээд хадан хавцалыг бүхэлд нь хамарахуйц бичээс хүртэл олдсон байдаг. Эртний бичиг соёлын үнэтэй дурсгал болох бүтээлийн амжилтыг онцлон тэмдэглэж үзэхэд үүнд газарзүйн өвөрмөц онцлог байгаа

төдийгүй, соёлын өвөрмөц шинж чанар байдгийг хүртэл тодорхойлсон байна.

Эртний энэтхэгээс гаралтай эдгээр бүтээлүүд маш ховор, гоо үзэмжтэй гэдгээрээ анхаарал татдаг. Эдгээр дурсгалууд нь зөвхөн эртний Энэтхэг төдийгүй Зүүн Азийн онцлог шинжийг өөртөө агуулсан байдаг. Зүүн Азид байрладаг Солонгосын хойг нь түүхэнд Хятадтай нягт харилцаатай байсан төдийгүй Азийн бусад газруудад ч ийм хэвлэлийн нийтлэг дурсгалууд олддог юм. Хэвлэмэл бүтээлийн түүхийг өөртөө шингээсэн дурсгалууд хятад соёлд гүн гүнзгий үндэслэгдсэн болохыг харж болно. Түүнчлэн соёлын өвөрмөц онцлогийг мөн өөртөө хадгалсаар ирсэн байдаг. Япончууд Чинь болон Хан улсын үед Хятадтай илүү ойр байсан байна.

Чин ши Хуанг Пэнг Лай Су Фүкүшү үхэшгүй мөнхийн улсад 3000 хүүхэд, залуусыг илгээсэн гэдэг. Сүй, Тан тэргүүтэй төлөөлөгчид мөн улс төр, эдийн засаг, соёл, урлаг, анагаах ухаан, шашин гэх мэтийг судлахын тулд Хятад руу олон элчийг илгээсэн байдаг. Энэ нь Японы соёлын хөгжилд дэмжлэг үзүүлэхэд эерэг үүрэг гүйцэтгэсэн бөгөөд Япон нь Хятадын соёлыг өөрийнхөө хэв маягаар хөгжүүлж, өөртөө шингээсэн гэж хэлж болно. Тухайлбал үүний өвөрмөц жишээгээр “юкиёо-е” хэвлэгдэж буй хатуу хуулбарыг төлөөлөх нь Хятадын модон блок хэвлэлийн хөгжсөн бас нэг хувилбар гэж үзэж болохоор байна.

Хэвлэмэл бүтээгдэхүүний дурсгалууд дунд Энэтхэгийн чулуун хэвлэлийн газар, Бауз, Японы модны хэвлэлт, Солонгосын шаазан эдлэлүүдийг нэрлэж болно. Бүгд өөр өөрийн гэсэн ялгаа онцлог шинжтэй. Бүс нутгийн янз бүрийн хэвлэгч-



дийн хувьд олон нийтэд нээлттэй, хэвлэн нийтлэх соёлын өвөрмөц, олон янзын аргатай байсныг дурдах хэрэгтэй. Хэвлэн нийтлэх соёл нь Азитивийн үлдсэн хэсэгт ч нэгэн зэрэг хөгжсөөр ирсэн байдаг. Бүс нутаг дахь чулуун сэтгүүлийн бүлгэм, хэвлэн нийтлэлийн түүхэнд бэх үлдээсэн нь ч бас дэлхийн соёлын өвийн нэг хэсэг болжээ. Хэвлэмэл бүтээгдэхүүний соёл яахын аргагүй соёл иргэншлийн баялагт зүй ёсоор багтана.

**Е**вропын соёл иргэншил, Америк тивийн соёл иргэншлүүд, далайн эргийн улс орнуудын соёл иргэншил нь түүхэндээ тодорхой саад бэрхшээлтэй үе шатуудыг даван туулж ирсэн байдаг. Гэхдээ тэдний хэвлэн нийтлэлийн соёл иргэншлийг дурдахгүй өнгөрөх боломжгүй юм. Хүн бүр өөрийн гэсэн шинж чанартай байдаг шиг Европын соёл иргэншилд ч өөрийн өвөрмөц онцлог бий. Европын хэвлэмэл бүтээлийн эх үүсвэрийг эртний чулуун уран зургаас эхтэй гэж үздэг. Соёл иргэншлийн хөгжил, бичиг соёл, хэвлэмэл бүтээгдэхүүний хөгжил, өөрчлөлтийн үе шат бүрийн гол хөшүүрэг нь дэвшилтэт соёл иргэншлийг хэвлэн нийтлэх явдал юм. Хэдийгээр далайгаар алслагдсан ч гэлээ Энэтхэгийн баруун хэсгийн уугуул ард түмэн Америкт суурьшсан гэж үздэг. Хатуу хуулбар хэлбэртэй дурсгалууд мөн олдсон байдаг. Нууцлаг эртний Маяагийн соёл иргэншил, эртний Энэтхэгийн эзэнт гүрэн, залгамжлагч Азтекийн эзэнт гүрэнд хамаарах дурсгалууд ч үүнд багтдаг. Эртний

Америкийн эртний олимпийн ололт амжилтыг харуулсан гээд Америк тивд эртний иргэншил байсан уу? гэдэг асуултанд хариулт болох дурсгалыг хэвлэмэл бүтээлийн дурсгалаар нотолж болно. Нэхмэл шүлгээс чулуун бичээс, ариун сүмийн шахмалаас аман шүлэг хүртэл гээд эдгээр нь Америкийн нууцлаг хэвлэн нийтлэх соёл иргэншлийг хайж олоход зориулсан мэдээлэл, бас нотолгоо юм. Дэлхийг соёл иргэншлийн өнцгөөс харахад газрын байршилаар хэвлэлийн хөгжлийг ангилж үзэж болохоор байна. Хэвлэмэл бүтээлийн хөгжил нь бүс нутгийн шинж чанарыг өөртөө тодорхой хэмжээгээр шингээсэн байгаа юм. Номхон далайн орчмоор хүрэл, хус холтос 400, Хойд өргөргүүд, өмнөд хагаст Модыг сийлбэрлэн хэвлэх нь түгээмэл байсан нь эрт дээр үеийн хүн төрөлхтний бөөгнөрөлийн соёл иргэншлийн билэг тэмдэг болж үлдээд байна. Эртний ард түмэн олон төрлийн ижил төстэй соёлыг бий болгож, тэр нь өнөөдрийн бидэнд хүртэл залгамжлагдан иржээ. Өнөөдрийн хатуу ширүүн хэвлэлийн зах зээлийн алсын хараа, судалгаа шинжилгээний замналыг илүү цогц байдлаар дүгнэж бас харах ёстойг энэ бүхэн бидэнд сануулж байна.

Орчуулсан: БНХАУ-ын Бээжингийн Багшийн Их Сургуулийн Сэтгүүл зүй олон нийтийн харилцааны сургуулийн магистрант А.Алтанцэцэг, Ж.Жавзмаа